

6

БҮРТГЭЛИЙН ЗАГВАР СУУРИЙН ШИНЭЧЛЭЛ

Ч. Дашсамбуу

Нягтлан бодох бүртгэлийн бичилт 4000 жилийн түүхтэй ч 1494 онд Италийн нэрт математикч Луки Пачиоли “Арифметик геометр нэгдэл хамаарал” бүтээлдээ данс, давхар бичилтийн системийг бүхэлд нь томъёолсон явдал хүн төрөлхтний бүтээсэн оюуны гайхамшигт ололтуудын нэг байв.¹ Тэр цагаас хойш хөгжлийн ээдрээтэй бөгөөд урт удаан замыг туулахдаа түүхэн ба одоогийн өртгийн бүртгэлийн загвар, капитал бүрдэл, тохируулга, сууриудын тухай ялгаатай үзэл баримтлал, тунхаглалууд үүсэн.

Нягтлан бодох бүртгэлийн үүсэл, хөгжлийн тойм, түүхэн сурвалжаас үзэхэд бүртгэлийн мөнгөн, тохируулсан, аккруэл (хуримтлал, хэрэгжилт) гэсэн үндсэн 3 суурь ихэд түгээмэл дэлгэрчээ. Нягтлан бодохын баримт, гүйлгээ, санхүүгийн элементүүдийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, мөнгөн урсгалын тайлагнал чухамдаа энэ сууриудаар ялгагддаг болохыг өнөөдөр ихэд түгээмэл хэрэглэгддэг бүртгэлийн дараах загварууд хангалттай нотлож өгнө.

Нягтлан бодохын баримт, гүйлгээ, мөнгөн урсгалыг нийтээр зөвшөөрсөн дээрх сууриудын тунхаглал, үзэл баримтлалд нийцүүлэн данс бүртгэлд тусгах нь нийтийн тогтсон жишиг билээ.

Мөнгөн суурьт бүртгэлээр орлого, санхүүжилтыг мөнгө цуглуулсан үед хэдийд олсноос үл хамаарч, харин зардал, сөрөг мөнгөн урсгалыг хэдийд гарсныг үл харгалзан мөнгө төлсөн үеэр бүртгэнэ. Орлогын хэмжилт мөнгөн цугларалт ба зардлын төлбөрт хамаарч, уялдаат зарчмыг үл хэрэгсэх учир санхүүгийн ухагдахуунуудын үзэл баримтлал, тунхаглалтай илт зөрчилддөг.

Харин орлого олсон, зардал гарсан цаг тухайд мөнгөөр орж гарсныг үл харгалзан хүлээн зөвшөөрч бүртгэхийг аккруэл (хуримтлал, хэрэгжилт) суурь гэдэг. Олон улсын жишиг бүртгэлд

¹ Раймонд де Рувей. Как возникла двойная бухгалтерия. -М.: Госфиниздат, 1958. с. 35; Гофман Г. Капелюш. Очерки развития форм бухгалтерского учета. -М.: Финансы, 1966.

чухамдаа аккруэл суурь буюу хуримтлуулан бүртгэх зарчмыг мөрдөнө. Аккруэл суурьт бүртгэлийн мэдээлэл мөнгөн суурийг бодвол бизнес нэгжийн өнөөгийн болон ирээдүйн мөнгөн гүйлгээ бий болгох чадварыг илүү сайн харуулдаг.

Ашгийн бус байгууллага, засгийн газрын бүртгэл, тэрчлэн хувь хүмүүс, хувийн үйлчилгээний байгууллагад ихэд дэлгэрсэн тохируулсан аккруэл сууриар орлогыг үүссэн бөгөөд хэмжих боломжтой үед, бараа материал, хангамжын зүйлсийн зарлагыг худалдаж авсан, бас ашигласан үеэр, хүүгийн зардлыг төлөгдөх ёстой өдөр нь, энкамбранс хэрэглэх зэргээс бусад тохиолдолд өглөг үүссэн хугацаанд зардлыг тус тус хүлээн зөвшөөрдөг.

Жилээс дээш ашиглалтын хугацаатай зарлагыг хөрөнгө байдлаар капиталжуулах бөгөөд ирээдүйн эдэлгээний хугацаанд элэгдүүлэх буюу хорогдуулдаг. Урьдчилж төлсөн, хуримтлагдсан зардлыг тууштай үздэггүй ч хойшлуулах ба зөвхөн хэрэглэсэн жилд хасагдах дүн болгоно. АНУ-д татварын зорилгоор хувь хүн ба хувийн үйлчилгээний байгууллагад энэ суурийг хэрэглэхийг зөвшөөрдөг ч 3 жилийн турш жил бүр 5 сая доллараас дээш орлоготой бизнес нэгжүүд хэрэглэхийг хоригложээ.²

Хүснэгт 1

Мөнгөн урсгалын тайлагнал

Баримт гүйлгээ (мөнгөн урсгал)	Мөнгөн суурьт бүртгэл	Аккруэл суурьт бүртгэл	Сайжруулсан аккруэл (мөнгөн) суурь
Борлуулалт	Мөнгөн борлуулалт, худалдааны авлага цуглуулалт	Мөнгөн ба зээлийн борлуулалт	Аккруэл суурьтай ижил
Худалдан авалт	Мөнгөөрх худалдан авалт, худалдааны өглөгийн төлбөр	Мөнгөн ба дансаарх худалдан авалтууд	Аккруэл суурьтай ижил
Бусад үйл ажиллагааны зардал	Хараахан бий болоогүй ч төлөгдсөн зардлууд	Гарсан боловч төлөгдөөгүй зардлууд	Мөнгөн суурьт бүртгэлтэй ижил
Бусад үйл ажиллагааны орлого	Хараахан бүрдээгүй ч хүлээн авсан орлого	Олсон боловч хараахан хүлээн аваагүй орлого	Мөнгөн суурьт бүртгэлтэй ижил
Элэгдэл	Хэвийн байдлаар бүртгэнэ	Хэвийн байдлаар бүртгэнэ	Хэвийн байдлаар бүртгэнэ
Авлага, эргэлзээтэй дансууд	Хүлээн зөвшөөрч бүртгэхгүй	Авлага, эргэлзээтэй дансыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ	Эргэлзээтэй дансыг зардал гэж хүлээн зөвшөөрнө
Дансны өглөг, хуримтлагдсан өглөг, зээл	Хүлээн зөвшөөрөхгүй	Бүхий л өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө	Хугацаатай дансны өглөг ба зээлийг хүлээн зөвшөөрнө

Мөнгөн суурьт бүртгэлд өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд илэрхийлэхгүй, харин тодруулгад тусгаж нийтлэх нь элбэг. Сайжруулсан мөнгөн суурьт бүртгэлд зөвхөн хугацаатай дансны өглөг, тэрчлэн зээллэгийг хүлээн зөвшөөрөх нь буй. Сайжруулсан мөнгөн сууриас аккруэл суурьт бүртгэлийн системд шилжихийн хирээр өр төлбөр хүлээн зөвшөөрөлт,

² Donald E. Kieso, Jerry J. Weygandt. Intermediate accounting, seventh edition: Монгол орчуулга, УБ, 2000 он, 92-р тал.

цар хүрээ тэлж эхэлнэ. Тохируулсан ба аккруэл суурьт бүртгэлийн системүүдэд өр төлбөрийн тухай ойлголт ижил буюу ихээхэн төстэй болж ирдэг.

Тэгэхлээр мөнгөн урсгалын хэмжилт, хүлээн зөвшөөрөх шалгуур, капитал бүрдлийн үзэл баримтлал, сууриудын сонголт, хэрэглээнээс хамаарч хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, орлого, өртөг, үр дүн зэрэг санхүүгийн тайлангийн элементүүд бүхэлдээ зөрчилтэй, ялгаатай тайлагнагдах нь ойлгомжтой. Нөгөө талаас сууриудийн хэрэглээ нягтлан бодохын ажил гүйлгээ, мөнгөн урсгал, хөрвөлтийн нөхцөл, агуулгыг анхан шатны баримт нэг бүрээр нягт задлан шинжлэхийг шаардах нь зүйн хэрэг.

Өнөөдрийг хүртэл Монголд нягтлан бодох бүртгэлийн аль суурийг хэрэглэж ирсэн вэ гэсэн эгэл асуултын хариуг олох нь нилээд ээдрээтэй бөгөөд ихэд төвөг удсан зүйл юм. Монголд холимог суурь байсан, орлого санхүүжилтыг мөнгөн сууриар хүлээн зөвшөөрч ирсэн гэж үзэх нь буй.

Манайд, тэрчлэн Орос, Зүүн Европ, Төв болон Зүүн Өмнөд Азийн тоталитор дэглэмт улс гүрнүүдэд саяхан хүртэл ажил гүйлгээний нарийвчилсан шинжилгээ, нийтээр зөвшөөрсөн сууриудийн хэрэглээний тунхаглал, санхүүгийн капитал бүрдэл, тохируулгад нийцсэн өдөр тутмын практик амьдралд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын тийм цэгцтэй горим, журам байгаагүйд хэргийн учир оршино.

Ийм нөхцөлд хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийг оролцуулан мөнгөн урсгалын гадаад санхүүгийн тайлагнал, орлого, өртөг, үр дүн тооцолт дэлхийн тогтсон жишиг, түүний дотор Англи-Саксоны загвараас хэрхэн зөрүүтэй хийгээд зөрчилтэй байх нь ойлгомжтой. Тэгээд ч тоталитор бүртгэлийн загварыг барууныхтай жиших нь утгагүй хэрэг.

Санхүүгийн элементүүдийн хэмжилт, хүлээн зөвшөөрөлтөд олон сууриуд буй ч мэдээллийн даяарчлал хийгээд дэлхийн хөгжлийн түүхэн хандлагаас үзвэл өнөөдөр олон улсын жишиг бүртгэлийн Англи-Саксон загвар, түүний дотор аккруэл суурийн хэрэглээ илт давамгайлах болсон. Манайд хэвших шинэ бүртгэл хуучин бүртгэлийн системээс **нэгд**, аккруэл суурь, **хөёрт**, мөнгөн үнэлгээ, **гуравт**, үнэт цаасд суурилдагаар ялгаатай. Шинэ бүртгэлийн тогтолцоог бүхэлд нь аккруэл суурь, үнэт цаас төвт, вексел, хүүгийн бүртгэлийн сонгомол хэв загвар гэж томъёолж болно.

Үндэсний бүртгэлийн системийг дэлхийн жишиг, олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх ажил манайд 1995 оноос эхлэж, зохих сургалт, судалгаа, туршилт бүхий олон шаттай төслүүд хэрэгжин, үндэсний бүртгэлээр нэлээд хэдэн стандартууд бэлтгэгдэв.

Ялангуяа Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэл, Аудитын хуулиудыг батлаж, зохих мэргэжлийн хяналтын байгууллага, хууль зүйн орчинг бүрдүүлсний дээр үндэсний бүртгэлийн хэд хэдэн эрхийн актуудыг шинэчлэн боловсруулсан явдал бүртгэлийн системийн тоталитор загварыг халж шинэчлэх ажилд үндсэн эргэлт болов.

Шинээр бэлтгэсэн бүртгэлийн заавар журмууд нягтлан бодох бүртгэлийн нийтээр зөвшөөрч тунхагласан түгээмэл зарчим, Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Хорооноос (IASB) боловсруулж 6 хэлээр тараадаг олон улсын бүртгэлийн стандартуудын шаардлага хийгээд АНУ-ын Санхүү Бүртгэлийн Стандартын Газраас (FASB) тараасан тунхагалуудын үзэл санаатай бүхэлдээ нийцэж, дэлхийн жишиг, бүртгэл, хяналт, калькуляцийн хөгжлийн түүхэн хандлагыг тусгаж байгааг энд дурдах нь чухал. Олон улсын жишгээр анх боловсрогдсоны хувьд төгс төгөлдөр биш ч цаашид сайжирч, шинэ шинэ эрхийн актаар баяжих нь ч зүйн хэрэг. Гэвч дурьдсан заавар журмуудад нийтээр зөвшөөрсөн санхүүгийн

бүртгэлийн түгээмэл тунхаглалууд, түүний дотор тохируулсан, аккруэл суурьт нягтлан бодох бүртгэлийн хэрэглээ, мөнгөн үнэлгээ, вексел, үнэт цаас, хүүгийн бүртгэлийн хэв загварууд одоо хир сонгодог хэлбэрээр төгс томъёологдож хэвшээгүй байна.

Тэр тусмаа тохируулсан, аккруэл суурьт бүртгэлийн системийн тунхаглал, тэдгээрийг төгсжүүлэхтэй холбогдсон үндэсний нягтлан бодох бүртгэлийн бодлого горим, түүний дотор санхүүгийн элементүүдийн тодорхойлолт, баримт гүйлгээний шинжилгээ, хүлээн зөвшөөрөлт, үнэлгээ, хэмжилт, нийтээр зөвшөөрсөн үндсэн, байж болох (венчмарк, альтернатив) хувилбарын сонголт зэрэг олон асуудал тодорхойгүй байгааг ч хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Хүснэгт 2

Монгол бүртгэлийн шинэчилсэн заавар (1995-2000 он)

№	Стандартын нэр, агуулга	Хэзээ баталсан	Хаана хэрэглэх
1	Нягтлаг бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар, түүнийг хэрэглэх журам	Сангийн сайдын 1995 оны 40 тоот тушаал	1996 оны 1 сард бүх аж ахуйн нэгжүүд
2	Нягтлан бодохын журнал бүртгэлийн маягт, заавар	Сангийн сайдын 1996 оны 402 тоот тушаал	1997 оны 1 сард бүх аж ахуйн нэгжүүд
3	Санхүүгийн тайлан тэнцэл, татварын тайлан хоорондын уялдааг зохицуулах журам	Сангийн сайдын 1997 оны 429 тоот тушаал	1998 оны 1 сард бүх аж ахуйн нэгжүүд
4	Хоршоонд хөтөлөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар	Сангийн сайдын 1999 оны 148 тоот тушаал	1999 оны 11-р сар, хоршооны байгууллага
5	Санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал	Сангийн сайдын 1999 оны 215 тоот тушаал	2000 оны 1 сар, бүх нэгжүүд, банк, даатгал
6	Санхүүгийн тайлан тодруулга	Сангийн сайдын 2000 оны 64 тоот тушаал	2000 оны 7 сар, бүх нэгжүүд, банк, даатгал
7	Нэгдсэн санхүүгийн тайлан ба охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын бүртгэл	Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 99 тоот тушаал	2001 оны 1 сар, нэгдсэн санхүүгийн тайлан бэлтгэгч бүх нэгжүүд

Манайд олон улсын бүртгэлийн стандартын нэвтрэлт хэрэгжилт сул байгаа ч үүнтэй холбоотой. 2000 онд 30000 гаруй бизнес нэгж, аж ахуйн газруудын дөнгөж 5 хувьд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт нэвтэрсэн гэсэн судалгааг мэргэжлийн байгууллага гаргажээ.³

Тэгэхлээр тоталитор загварын эсрэг сууриудын тунхаглал, үзэл баримтлал, онолын сурвалжид нийцүүлэн тохируулсан, аккруэл суурьт бүртгэлийн бүрдэл, хэрэглээг төгс тодотгож, зөв гольдрофт оруулах нь Монгол дахь бүртгэлийн шинэчлэлийн нэн тулгамдсан, ээдрээтэй асуудлын нэг гэж хэлж болно. Чухамдаа энэ чиглэлд бүх судалгаа, сургалт, туршилтын ажлын голыг чиглүүлбээс зохино.

Аккруэл суурийн томъёолол, төгс хэрэглээг төлөвшүүлэхтэй холбогдож Англи-Саксон загвар, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хорооны үндсэн баримт бичгийн тунхаглалд нийцсэн "Санхүүгийн тайланг бэлтгэх, мэдээлэх үндсэн зарчим" хэмээх нийт үндэсний заавар журам, бүртгэлийн суурь стандарт гэж хэлж болохуйц үндсэн баримт бичиг, эрхийн акт чухамдаа манайд үгүйлэгдэж байгаа билээ.

³ Санхүүгийн мэдээ сонин, 2000.5.30, №15 (16)

Энэ тунхаглал, үзэл баримтлал, баримт бичигт гадаад санхүүгийн тайлангийн цар хүрээ, нийтлэг зориулалттай тайлангийн зорилго, зарчим, нийтээр зөвшөөрсөн урьдчилсан таамаглалууд, санхүүгийн элементүүдийн тодорхойлолт, үндсэн шинжүүд ба хүлээн зөвшөөрөх шалгуур, үнэлгээ хэмжилтийн үндэс, нийтээр зөвшөөрсөн үндсэн (венчмарк), боломжит (альтернатив) хувилбар сонголт, аккруэл суурийн хэрэглээнд холбогдох нягтлан бүртгэлийн ерөнхий ба тусгай бодлого горимуудыг тоталитор загварын эсрэг сэргүүлж, нэг бүрчлэн хуульчлан тусгах нь зүйтэй байна.

Тохируулсан, аккруэл суурьт бүртгэлд нийцүүлэн дээрх тунхаглалуудыг банк, даатгалын системийг оролцуулан ашгийн төлөө бизнес орчны бүх аж ахуйн нэгж, тэрчилэн засгийн газрын бүртгэл, ашгийн бус төр, олон нийтийн байгууллагын хүрээнд авч хэрэглэхээр ялгаатай бэлтгэх хэрэгтэй.

Сууриудын тунхаглал, үзэл баримтлал, онолын сурвалжид нийцүүлэн аккруэл суурьт бүртгэлийн томъёолол, хэрэглээг төгсжүүлэхдээ баримт, гүйлгээ, санхүүгийн элемент нэг бүрийн ойлголт, хүлээн зөвшөөрөх шалгуур, үнэлгээ хэмжилтийн загварыг эргэн хянаж тодотгох нь чухал. Энд баримт гүйлгээ, мөнгөн урсгал, хөрвөлтийн хүлээн зөвшөөрөлт ба бүртгэл тайлагнал дахь нийтээр зөвшөөрсөн хувилбаруудын сонголт хийгээд тодорхой салбар, үйлдвэрлэлийн чиглэлд хамрах онцлог бодлого горимыг тодорхой болгох чиглэлээр бүртгэлийн үндэсний стандарт, холбогдох заавар журмуудыг нэг бүрчлэн эргэн хянаж, хуульчлан тусгамаар байна.

Бидний өргөн барьсан "Санхүүгийн мэдээ тайланг бэлтгэх, мэдээлэх үндсэн зарчим" нягтлан бодох бүртгэлийн стандартын үндсэн баримт бичиг, тунхаглалын төсөлд мэдээллийн даяарчлалд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын үүрэг, Монгол дахь бүртгэлийн шинэчлэлийн гол үзэл баримтлал хийгээд мэдээллийн даяарчлалд нэгдэх концепци, аккруэл суурьт нягтлан бодох бүртгэлийн хэрэглээ, үндэсний хэв загвар ба онцлогийг бүхэлд нь томъёолохыг хичээсэн юм. Тунхаглалд нийтлэг зориулалттай санхүүгийн тайлангийн зорилго, цар хүрээ, зарчим, нийтээр зөвшөөрсөн урьдчилсан таамаглалууд, мэдээллийн чанарын шинжүүд, элементүүдийн ойлголт, хүлээн зөвшөөрөх шалгуур, үнэлгээ ба хэмжилт, аккруэл суурийн хэрэглээнд холбогдох нягтлан бодох бүртгэлийн ерөнхий ба тусгай бодлого горимуудыг өнөөдрийг хүртэл манайд хэвшиж тогтсон бүртгэлийн саармаг систем, тоталитор загварын эсрэг сэргүүлэн тавьсан.

Санхүүгийн тайлагналд түүхэн ба одоогийн өртгийн гэгдэх олон загвар, суурь, хэмжилтүүд буй ч мэдээллийн даяарчлал хийгээд дэлхийн хөгжлийн түүхэн хандлагаас үзвэл өнөөдөр Англи Сагсоны загвар, аккруэл суурь, нэрлэсэн санхүүгийн капиталын үзэл баримтлал ба түүхэн өртгийн хэмжилт илт давамгайлах болсон. Одоогийн өртгийн загварт капиталын бүтээмж, чадавх илүү тусч, татвар хамгаалалт сайжирдаг ч хэмжилт ихэд ярвигтай, үргэлж эвх зээлийн үнэтэй дүйж, бас санхүүгийн үед хэвээр хадгалагдаж чадахгүй. Харин түүхэн өртгийн загвар нягтлан бодох бүртгэлийн хэмжилт, тайлагналд нилээд ашигтай бөгөөд бусад сууриас туйлын энгийн ба найдвартайд тооцогддог. Тэрээр туйлын тодорхой бөгөөд шалгаж болох зүйл. Түүхэн өртгийг нэгэнт хэмжсэн бол хөрөнгийн эдэлгээний турш тогтвортой мөрддөг.